

[illegible]

Төслийн дугаар: BMZ No. 201667054, 201868272

Төслийн нэр: "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III" төсөл

Хөгжлийн түнш/ Санхүүжүүлэгч байгууллага: Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээх босголт, Зээлийн банк (KfW)

"БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ II, III" ТӨСЛИЙН 2024 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

(жилийн эцсийн байдалаар)

Огноо: 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

№	УАТ №	Төсөл, арга хэмжээний нэр	Зарлын төрөл /БУА, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ гм/	Тайлбар, тодруулга	Худалдан авах ажиллагааны биелэлтийн хувь
1	2.18	Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны барилга барих	БУА	Тендер шалгаруулалтын процесс эхлээгүй. Барилгын ажлын зураг төсвийг "Бьюлдингс Технолож" ХХК хийж гүйцэтгэж байна. Барилгын хөгжлийн төвөөр тус барилгын зураг, төсөв батлагдаагүй байгаа тул тендер шалгаруулалт эхлэх боломжгүй байдалтай байна.	Үнэлэх боломжгүй.
2	2.19, 3.15	Байгаль хамгаалагчийн 25 байр барих	БУА	Тендер шалгаруулалтын процесс эхлээгүй. Барилгын ажлын зураг, төсвийг "Инженеринг суппорт сервис" ХХК хийж гүйцэтгэж байна. Барилгын хөгжлийн төвөөр тус барилгын зураг, төсөв батлагдаагүй байгаа тул тендер шалгаруулалт эхлэх боломжгүй байдалтай байна.	Үнэлэх боломжгүй.
3	1.01	SMART програмын хэрэглээнд зориулж таблет, ухаалаг гар утас ТХГН-т нийлүүлэх	Тоног төхөөрөмж	Тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Захиалагчаар Тендерийн ажлын даалгавар 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр батлагдлаа. Гэрээ байгуулахын өмнөх хурлыг 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдөр зохион байгууллаа. Тусгай хамгаалалттай газар нутагт байгаль орчны хээрийн эргүүл, хяналт шалгалтыг ахисан түвшинд хийх, байгаль хамгааллын мэдээ дата цуглуулан хянаж, удирдах арга зүй бүхий smart программыг практикт нэвтрүүлж байгатай уялдуулан хээр хөдөө байгаль цаг уурын янз бүрийн нөхцөлд хяналт мониторинг хийж ажиллах үед нарийвчилсан мэдээ баримт цуглуулах, тэмдэглэх, дамжуулах 556 ширхэг дижитал хэрэгсэл (512 ширхэг ухаалаг гар утас болон 44 ширхэг таблет)-ийг 150 хоногийн хугацаанд 640,056,400.0 төгрөгөөр нийлүүлэх №24/379 дугаартай гэрээг Захиалагч 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр тендэрт шалгарсан "Ай Си Ай Систем Монголиа" ХХК-тай байгуулаа.	100
4	1.02	Аймгуудын БОАЖГ-ыг үндсэн тоног төхөөрөмжөөр хангах	Тоног төхөөрөмж	Эхэлж зарласан тендер шалгаруулалт амжилтгүй болсон. Захиалагчаар Ажлын даалгавар 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр батлагдлаа. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/256 дугаар тушаалаар тус тендер шалгаруулалтын үнэлгээний хороо байгуулагдлаа. Тендер хүлээн авах эцсийн хугацаа (2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 10:00 цаг) н дотор ирсэн тендерүүдийг 10:30 цагт нийтийн өмнө нээж, тендерийн үнэлгээг хийсэн. KfW-аар батлагдсан тендерийн үнэлгээний тайланг Зөвлөмжийн хамт 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр Захиалагчид хүргүүлэн танилцуулж баталгаажуулсан. Тендэрт оролцогч нарт мэдэгдлийг 07 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн. Тендер амжилтгүй болсныг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон Төслийн вэбсайт дээр байршууллаа. Дахин зарлах No objection хүссэн мэйлийг 2024-07-26 өдөр явуулсан бөгөөд тус хүсэлтийг KfW-аас 2024-07-29 өдөр No Objection -аар баталгаажуулсан	100
		Дахин зарласан "Аймгуудын БОАЖГ-ыг үндсэн тоног төхөөрөмжөөр хангах"		Дахин зарласан тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Захиалагчаар Тендерийн ажлын даалгавар 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр батлагдлаа. Гэрээ байгуулахын өмнөх хурлыг 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулаа. ээрийн нөхцөлд ажиллах, судалгаа шинжилгээ, хяналт, мониторинг хийхэд нэн шаардлагатай байгаа 9 нэр төрлийн 2741 тоо ширхэг үндсэн тоног төхөөрөмжийг 150 хоногийн хугацаанд 562,576,000.0 төгрөгөөр нийлүүлж, 16 аймгийн БОАЖГ-уудад хүлээлгэн өгөх №24/409 дугаар гэрээг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Захиалагч тендэрт шалгарч гэрээ байгуулах эрх олгосон "Ай Си Ай Систем Монголиа" ХХК-тай байгуулаа.	
5	1.03	Аймгуудын БОАЖГ-ыг дүрэмт хувцсаар хангах	Тоног төхөөрөмж	Тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Захиалагчаар Тендерийн ажлын даалгавар 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр батлагдлаа. Гэрээ байгуулахын өмнөх хурал 2024-11-22-ны өдөр зохион байгуулагдлаа. Байгаль орчин, аялал жуулчлалын 16 газар, төслийн зорилтот 17 хамгаалалтын захиргаа, шинээр байгуулагдсан 6 хамгаалалтын захиргаанд 4 улирлын нийт 17 нэр төрлийн 9758 тоо ширхэг барааг 180 хоногийн хугацаанд 533,461.92 евро (НӨАТ болон бусад татвар хураамж хасаж тооцсон үнэ)-гоор үйлдвэрлэж, захиалагчид хүлээлгэн өгөх 24/487 дугаар гэрээг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Захиалагч тендэрт шалгарч гэрээ байгуулах эрх олгосон "Асралтбаян хайрхан" ХХК-тай байгуулаа.	100
6	1.05	Ойн газар, сумдын ойн ангиудад мониторингийн судалгааны тоног төхөөрөмж нийлүүлж, сургалт явуулах	Тоног төхөөрөмж	Эхэлж зарласан тендер шалгаруулалт амжилтгүй болсон. Захиалагчаар Ажлын даалгавар 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/257 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороо байгуулагдлаа. Төслийн зөвлөх багийн ахлах зөвлөх Г.Александр тус тендерийг нийтэд зарлахыг хойшлуулах тухай имэйл 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн. ирүүлсэн учраас үнэлгээний хорооны 01 тоот зохион байгуулагдаагүй байсаар 2024 оны 08 дугаар 19-ний өдөр Г.Александр мэйл ирүүлсэн. Г.Александрын мэйлийг үндэслэн үнэлгээний хорооны 01 тоот хурал зохион байгуулагдаж, тендерийн урилгыг 09 дүгээр сарын 10-ны өдөр нийтэд зарлан мэдээллээ. Тендер хүлээн авах эцсийн хугацаа (2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 10:00 цаг)-н дотор ирсэн тендерийг 10:30 цагт нийтийн өмнө нээж, тендерийн үнэлгээг хийсэн. KfW-аар батлагдсан тендерийн үнэлгээний тайланг Зөвлөмжийн хамт 2024-10-14 өдөр Захиалагчид хүргүүлэн танилцуулсан. Тендэрт оролцогч нарт мэдэгдлийг 2024-10-16 өдөр хүргүүлсэн. Тендер амжилтгүй болсон тухай тендерийн үр дүнг 2024-10-16 өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон Төслийн вэбсайт дээр байршуулсан.	50
		Дахин зарласан "Ойн газар, сумдын ойн ангиудад мониторингийн судалгааны тоног төхөөрөмж нийлүүлж, сургалт явуулах"		Дахин зарласан тендер шалгаруулалт амжилтгүй болсон. KfW-д тендер амжилтгүй болсон тухай, дахин зарлах зөвшөөрөл хүссэн мэйл явуулсны дагуу KfW-аас 2024-10-22 өдөр зөвшөөрөл ирсэн. Тендерийг 2024.10.24-ний өдөр дахин зарлалаа. Тендер хүлээн авах эцсийн хугацаа (2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 14:00 цаг)-н дотор ирсэн тендерийг 14:30 цагт нийтийн өмнө нээж, тендерийн үнэлгээг хийсэн. KfW-аар батлагдсан тендерийн үнэлгээний тайланг Зөвлөмжийн хамт 2024-11-28 өдөр Захиалагчид хүргүүлэн танилцуулсан. Тендэрт оролцогч нарт мэдэгдлийг 2024-12-03 өдөр хүргүүлээ. Дахин зарласан тус тендер шалгаруулалт амжилтгүй болсон тухай тендерийн үр дүнг 2024-12-03 өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон Төслийн вэбсайт дээр байршуулсан. Донорт 2024-12-05 өдөр тендер шалгаруулалт дахин амжилтгүй болсон талаар мэдэгдлээ.	

7	2.16	Цаг уурын автомат станцаар хангах (Говь-Алтай- 2, Ховд аймаг- 2)	Тоног төхөөрөмж	Тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Захиалагчаар Тендерийн ажлын даалгавар 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр батлагдлаа. Гэрээ байгуулахын өмнөх хурал 2024-08-30 өдөр зохион байгууллаа. Ард иргэдийг цаг агаарын мэдээллээр хангах байгаль орчны ажиглалт мониторингийн ажлыг гүйцэтгэхэд стандарт технологийн горимыг хангахуйц орчин үеийн өндөр нарийвчлалтай 4 ширхэг Цаг уурын автомат станцыг 150 хоногийн хугацаанд 432,440,000.0 төгрөгөөр нийлүүлэн, Ховд, Говь-Алтай аймгуудын Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдэд хүргэж өгөх №24/379 дугаар гэрээг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Захиалагч тендерт шалгарч гэрээ байгуулах эрх олгосон "АЧВС" ХХК-тай байгууллаа.	100
8	6.01	Төсөл хэрэгжүүлэх нэгж, зөвлөх багийн албан хэрэгсэнд шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангах	Тоног төхөөрөмж	Тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Тендерийн ажлын даалгавар 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Захиалагчаар батлагдлаа. Гэрээ байгуулахын өмнөх хурлыг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Тендерт шалгарсан "Амугэ" ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр №24/187 тоот гэрээг Захиалагч байгууллаа.	100
9	1.06	ТХГН-ийн батлагдсан 5 менежментийн төлөвлөгөө болон төслийн танилцуулга, олон нийтэд зориулсан мэдээллийг боловсруулж хэвлэх	Зөвлөх үйлчилгээ	Тус төсөл, арга хэмжээ амжилттай хэрэгжсэн. Говийн бага ДЦГ, Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн Менежментийн төлөвлөгөөг Төслийн зөвлөх баг боловсруулан өөрийн санхүүжилтээр хэвлүүлэхээр Захиалагчид батлуулахаар хүргүүлсэн.	100
10	2.01, 3.01	Хамгаалалтын захиргааны оффисын барилгын хэрэгцээ, шаардлагыг боловсруулах	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалт эхлээгүй. Ажлын даалгавар 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Захиалагчаар батлагдсан. KfW-аас тус тендер шалгаруулалтын процессыг зогсоох шийдвэр гарсныг Төслийн зөвлөх багаас мэдэгдсэн тул тендер шалгаруулалтыг үнэлэх боломжгүй.	-
11	2.02, 3.02	Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл, зардлын тооцоог боловсруулах	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Тендерийн ажлын даалгавар 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Захиалагчаар батлагдлаа. Гэрээ байгуулахын өмнөх хурлыг 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгууллаа. ТХГН-ийн сүлжээний хэмжээнд байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, өндөр уул, говь цөл, ойт хээрийн гэсэн байгалийн 3 бүс бүслүүрийн онцлогт тохирсон байгаль хамгаалагчийн нэг загварын зураг төсөл, төсөв боловсруулах ажлыг 54,500,000.0 төгрөгөөр хийж гүйцэтгүүлэх 24/163 дугаар гэрээг Захиалагч 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр "Инженеринг Суппорт Сервис" ХХК-тай байгууллаа.	100
12	2.04, 3.04	Алсын удирдлагатай камер, нарны зайн хураагуур хэрэгцээ шаардлагыг тодорхойлох	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Тендерийн ажлын даалгавар Захиалагчаар 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан. Гэрээ байгуулахын өмнөх хурлыг 2024-08-30 өдөр зохион байгууллаа. Алсын удирдлагатай камер, нарны зай хураагуурын хэрэгцээ шаардлагын одоо байгаа нөхцөл байдлын талаар цогц дүгнэлт өгөх, тоног төхөөрөмжийн хэрэгцээ, худалдан авах, суурилуулах, ажиллуулах, ашиглалт засвар үйлчилгээний тогтвортой байдлыг хангахад шаардлагатай арга хэмжээний талаар нарийвчилсан зөвлөмж боловсруулах үйлчилгээг 60,610,000.0 төгрөгөөр 90 хоногийн хугацаанд хийж гүйцэтгүүлэхээр Захиалагч тендерт шалгарч гэрээ байгуулах эрх олгосон "Дүйнхэр тэргүүн" ХХК-тай 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр №24/214 дугаар гэрээг байгууллаа.	100
13	2.05, 3.05	Төслийн II/III үе шатны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалтын процесс эхлээгүй. KfW-аас тус тендер шалгаруулалтын процессыг зогсоох шийдвэр гарсныг Төслийн зөвлөх багаас мэдэгдсэн тул тендер шалгаруулалтыг үнэлэх боломжгүй.	Үнэлэх боломжгүй
14	2.09	Орчны бүсийн сонгогдсон нэг дэх суманд бэлчээрийн загвар төслийг хэрэгжүүлэх	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалтын процесс эхлээгүй. Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.	Үнэлэх боломжгүй.
15	2.09	Орчны бүсийн сонгогдсон хоёр дахь суманд бэлчээрийн загвар төслийг хэрэгжүүлэх	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалтын процесс эхлээгүй. Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.	Үнэлэх боломжгүй
16	2.09	Орчны бүсийн гурав дахь суманд бэлчээрийн загвар төслийг хэрэгжүүлэх	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалтын процесс эхлээгүй. Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.	Үнэлэх боломжгүй.
17	2.10	Хан Хөхийн дархан цаазат газарт ойн загвар төслийг хэрэгжүүлэх	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалтын процесс эхлээгүй. Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.	Үнэлэх боломжгүй.
18	2.21	Хяргас нуурын БЦГ-ын (Увс аймгийн Завхан сум) орчны бүсэд бирвааз барих хэрэгцээ шаардлага, үзэл баримтлалыг боловсруулах	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Тендерийн ажлын даалгавар Захиалагчаар 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр батлагдлаа. Гэрээ байгуулахын өмнөх хурлыг 2024-11-19 өдөр зохион байгууллаа. Хяргас нуурын БЦГ дахь перевозны тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн байдал үнэлгээ хийх, холбогдох хууль, дүрэм журмууд болон усан замын тээвэрт тавигддаг шаардлага стандарттай хэрхэн нийцж байгаа, нийцүүлэх мөн түүнчлэн зохион байгуулалтын хэрэгцээ шаардлагын дүн шинжилгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлыг тус тендерт шалгарч гэрээ байгуулах эрх олгосон "Дөрвөн тэнхлэг" ХХК-аар 90 хоногийн хугацаанд 73,095,800.0 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Захиалагч 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 24/486 дугаар бүхий гэрээг байгууллаа.	100
19	3.09	Монгол элсний байгалийн цогцолбор газарт ойн загвар төслийг хэрэгжүүлэх	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалтын процесс эхлээгүй. Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.	Үнэлэх боломжгүй.

20	4.04	Байгаль хамгаалагчийн сургалтын хөтөлбөрийн дагуу судалгаа, мониторингийн сургалт зохион байгуулах	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Тендерийн ажлын даалгавар 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Захиалагчаар батлагдлаа. Гэрээ байгуулахын өмнөх хурлыг 2024-09-25 өдөр зохион байгууллаа. Байгаль орчин, аялал жуулчлал /Хуучин нэршилээр/-ын сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/189 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр"-ийн дагуу байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх анхан болон дунд шатны сургалтын материал, модулийг иж бүрнээр (сорилын тест, бие даалтын сэдэв, даалгавар, үзүүлэн график, зураг, жишээ, видео бичлэг г.м) боловсруулан батлуулах, батлуулсан сургалтын материалын дагуу байгаль хамгаалагчдад сургалт зохион байгуулж, нийшлийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх зөвлөх үйлчилгээний ажлыг тендерт шалгарч гэрээ байгуулах эрх олгосон "Дэлгэр консалтинг" ХХК-аар 150 хоногийн хугацаанд 109,500,000.0 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Захиалагч 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 24/424 дугаар гэрээг байгууллаа.	100
21	4.09	Монгол орны ТХГН-ийн сүлжээний хэмжээнд мэдээллийн санг стандартын дагуу байгуулах	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Тендерийн ажлын даалгавар Захиалагчаар 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр батлагдлаа. Гэрээ байгуулахын өмнөх хурлыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Захиалагч тендерт шалгарсан оролцогч "Битсофт" ХХК-тай сарын 20-ны өдөр хүртэл үргэлжлэх 69,000,000.0 төгрөгийн 24/174 дугаар гэрээг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр байгууллаа.	100
22	5.03	Эрэн нуурын нөхөн сэргээлтийн ажлын БОНН-ийн урьдчилсан үнэлгээ/үнэлгээ, тухайн барилгын БОНМТ боловсруулах	Зөвлөх үйлчилгээ	Тус төсөл, арга хэмжээ амжилттай хэрэгжсэн. Төслийн Донор, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газартай хамтран ажилласнаар Эрэн хуурын нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд гарч буй 841,300,000.0 төгрөгийг Монгол Улсын хөрөнгө оруулалтын санхүүжилтэд тооцохоор боллоо.	100
23	6.05	Төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн бичиг баримтын мэргэжлийн орчуулга хийлгэх	Зөвлөх үйлчилгээ	Тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Захиалагчаар тендерийн ажлын даалгавар 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан. Гэрээ байгуулахын өмнөх хурлыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа. • Бичмэл текст, хууль эрх зүй, техникийн болон үүнтэй төстэй бичмэлүүдийг утга санааны бүрэн бүтэн байдал, илэрхийллийн үнэн зөв байдлыг алдагдуулахгүйгээр англи хэлнээс монгол хэл рүү, монгол хэлнээс англи хэл рүү стандартын дагуу орчуулах ажлыг 17,750,000.0 төгрөгөөр хийж гүйцэтгүүлэх 24/163 дугаар гэрээг Захиалагч 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр "Дабль Эл" ХХК-тай байгууллаа.	100
24	4.06	ЮНЕСКО-ийн Хүн ба шим мандлын хөтөлбөрт зарим тусгай хамгаалалттай газар нутгийг бүртгүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ	Зөвлөх үйлчилгээ	Он дамжсан /2023-2024/ тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Гэрээ байгуулахын өмнөх хурал 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зохион байгууллаа. "Байгаль, зэрлэг амьтан хамгаалах үндэсний нийгэмлэг" НҮТББ нь цуврал нэвтрүүлгээр дамжуулан өвөрмөц байгалийн үзэсгэлэнгээр дэлхийд гайхагдах Монголын их говийн хосгүй үнэ цэнийг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээлэл хүргэх ажлыг 12 сарын хугацаанд 72,500,000.0 төгрөгөөр хийж гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний №24/14 дугаартай гэрээг 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Захиалагчтай байгууллаа.	100
25	2.17	Говийн Их Б ДЦГ-ын захиргааны барилгын одоогийн зураг төсөл, зардалын тооцоог шинэчлэх	Зөвлөх үйлчилгээ	Он дамжсан /2023-2024/ тендер шалгаруулалт амжилттай явагдсан. Тендерийн үнэлгээний хороог ТНБД-ын 2023.11.02-ны өдрийн А/377 дугаартай тушаалаар байгуулсан. Ажлын даалгавар 2023.11.28-ны өдөр захиалагчаар батлагдсан. Тус ажил нь барилгын зургийн авторын эрхтэй ажил тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг БОАЖЯ-ны ТНБД-д 2023.12.08-ны өдөр танилцуулсан. "Быолдингс Техноложи" ХХК-д 2023.12.14-ний өдөр гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлээ. Захиалагч "Быолдингс Техноложи ХХК-тай 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр гэрээ байгууллаа.	100
Төслийн худалдан авах ажиллагааны 2024 оны биелэлтийн дундаж хувь					67.4

Тайлбар: Төслийн зөвлөх багийн зүгээс тухайн оны төлөвлөгөөнд батлагдсан төсөл, арга хэмжээнүүдийн Ажлын даалгавар (Тус төсөл, арга хэмжээний зорилго, зорилт, хамрах хүрээ, төсөвт өртөг, техникийн тодорхойлолт)-ыг боловсруулан Захиалагчаар батлуулж, Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүлээлгэн өгдөг. Энэ онд Төсөл хэрэгжүүлэх нэгж өөрөө боловсруулан Захиалагчаар батлуулсан 2 төсөл, арга хэмжээ, Төслийн зөвлөх багаас боловсруулан Захиалагчаар батлуулан хүлээлгэн өгсөн 14 нийт 16 тендер шалгаруулалтыг амжилттай зохион байгуулсан.

Ажлын даалгавар хүлээлгэж өгөөгүй төсөл, арга хэмжээг Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс тендер шалгаруулалтыг зохион байгуулах боломжгүй.

ХЯНАСАН:

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

М.БОЛДБАЯР

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ч ОЮУНБИЛЭГ

ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН АЖИЛТАН

Төслийн дугаар: BMZ No. 201667054, 201868272
Төслийн нэр: "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III" төсөл
Хөгжлийн түвш/ Санхүүжүүлэгч байгууллага: Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголт, Зээлийн банк (KfW)

ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖИЖ ЭХЛЭЭГҮЙ ТЕНДЕРИЙН МЭДЭЭЛЭЛ

Огноо: 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

№	ҮАТ №	Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг /ЕВРО/	Тайлбар, тодруулга
1	2.18	Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны барилга барих	1,400,000.0	Барилгын ажлын зураг төсвийг "Бьюлдингс Техноложи" ХХК хийж гүйцэтгэж байна. Тус компанийн гэрээний хугацаа сунгагдсан бөгөөд Барилгын хөгжлийн төвөөр тус барилгын зураг, төсөв батлагдаж тендерийн үнэлгээний хороонд ирээгүй байгаа тул тендер шалгаруулалт эхлээгүй.
2	2.19, 3.15	Байгаль хамгаалагчийн 25 байр барих	750,000.0	Барилгын ажлын зураг, төсвийг "Инженеринг суппорт сервис" ХХК хийж гүйцэтгэж байна. Тус компанийн гэрээний хугацаа сунгагдсан бөгөөд Барилгын хөгжлийн төвөөр тус барилгын зураг, төсөв батлагдаж тендерийн үнэлгээний хороонд ирээгүй байгаа тул тендер шалгаруулалт эхлээгүй.
3	2.01, 3.01	Хамгаалалтын захиргааны оффисын барилгын хэрэгцээ, шаардлагыг боловсруулах	20,000.0	Ажлын даалгавар 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Захиалагчаар батлагдсан. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/290 дүгээр тушаалаар тендерийн үнэлгээний хороо байгуулагдлаа. KfW-аас тендер шалгаруулалтын процессыг зогсоох мэйл ирүүлсэн. Үүнийг үндэслэн тендер шалгаруулалт эхлэх боломжгүй байдалтай байна.
4	2.05, 3.05	Төслийн II/III үе шатны орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөтгөн хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах	75,000.0	Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.
5	2.09	Орчны бүсийн сонгогдсон нэг дэх суманд бэлчээрийн загвар төслийг хэрэгжүүлэх	100,000.0	Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.
6	2.09	Орчны бүсийн сонгогдсон хоёр дахь суманд бэлчээрийн загвар төслийг хэрэгжүүлэх	100,000.0	Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.
7	2.09	Орчны бүсийн гурав дахь суманд бэлчээрийн загвар төслийг хэрэгжүүлэх	100,000.0	Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.
8	2.10	Хан Хөхийн дархан цаазат газарт ойн загвар төслийг хэрэгжүүлэх	100,000.0	Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.
9	3.09	Монгол элсний байгалийн цогцолбор газарт ойн загвар төслийг хэрэгжүүлэх	100,000.0	Төслийн зөвлөх багаас тус тендерийн ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүй тул тендер шалгаруулалт эхлээгүй.
2024 онд хэрэгжээгүй тендерийн төсөвлөсөн нийт өртөг			2,745,000.0	Төслийн зөвлөх багаас 2024 онд худалдан авах ажиллагаагаар хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулсан төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг нь 4,434,000.0 Евро . Үүнээс ажлын даалгаврыг боловсруулан Захиалагчаар батлуулж, тендерийн үнэлгээний хороонд ирүүлээгүйгээс шалтгаалан тендер шалгаруулалт эхлээгүй төсөл, арга хэмжээний нийт өртөг нь энэ онд худалдан авах ажиллагаанд төсөвлөсөн өртөг (4,434,000.0 Евро)-ийн 61.91 хувийг эзэлж байна.

ХЯНАСАН:
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН АЖИЛТАН

М.БОЛДБАЯР

Ч.ОЮУНБИЛЭГ